

Аудитын тайлан

АГУУЛГА

ХУУДАС

**Нэмэлтмэдээлэл авахыг хүсвэл
доорх хаягаар харилцана уу:**

Захирал Б.Шатар
Утас: 89383852
Цахим хаяг: baldandorjshatar@yahoo.com

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Гэрээт аудитор Д.Оюунбат
Утас: 89585807
Цахим хаяг: oyuna200702@yahoo.com

Хаяг:
Дундговь аймаг Сайнцагаан сум 7 дугаар
баг

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан.....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	4
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	9
3.1	«management_zurchil1».....	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын захирал А.Батжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Тус газар нь 2017 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 15 дугаартай албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, гэрээт аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж–Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ нь 2017 онд хэрэглэгчдийг дулаан, хэрэглээний хүйтэн, халуун усаар тогтмол найдвартай хангах гэсэн зорилгын хүрээнд “Гүний усыг олборлон эрүүл ахуйн стандартад тохирсон цэвэр ус түгээх” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын удирдлага нь дараахь хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- НД-ын тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- ХАБЭА-н тухай хууль

- Татварын ерөнхий хууль
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хууль

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын НБББББ нь 2017 онд боловсруулагдан мөрдөгдөж байгаа боловч эрх бүхий албан тушаалтны тушаалаар баталгаажуулж, зарим дансны дугаар санхүүгийн програмын дансны дугаартай тохирохгүй байна.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ нь 2017 оны санхүүгийн үйл ажиллагаандаа “Ординат” ХХК-ийн “Винница” програмыг 2013 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд ашиглалтын явцад 2 удаа програмын шинэчлэл хийгдсэн байна.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн тодорхойлсон уламжлалт болон хяналтын эрсдэлийн дагуу горим хэрэгжүүлэн тэдгээрийг ТАБ-СТА-АБ.1-АБ.8 маягтуудаар баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудалд аудитыг чиглүүлэн, аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгийн дүнг сонгов.

Санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгийн дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогын дүнд тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагддаггүй орлого тооцогдох магадлалтай бөгөөд зардлын дүнд бодит бус

элэгдлийн зардал орсон байдаг тул цэвэр хөрөнгийн дүнг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг цэвэр хөрөнгийн дүн болох 1,962,489.7 мянган төгрөгөөс 0.5% буюу 9,812.4 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлын түвшинд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж /ТАБ-СТА-В-1/ маягтаар баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 0.5%-иар тооцсон нь сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсантай холбоотой.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын төлөвлөлтөөр нийт 8 дансанд эрсдэлтэй гэж тооцож, горим, сорил хэрэгжүүлэх явцад 5 дансанд алдаа зөрчил илрээгүй тул нарийвчилсан горим сорил хийгдээгүй бөгөөд зөрчилтэй гэж үзсэн 3 дансанд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баталгаажуулав. /ТАБ-СТА-В.3.1-В.3.3/, /ТАБ-СТА-В.3.9/

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараахь байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	2,966.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн		0	
4	Аудитын явцад залруулсан	0	0	
5	Залруулагдаагүй алдаа	0	0	
6	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
7	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	1	2,966.0	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг /ТАБ-СТА-В-4.3-4.4/ маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. НБББББ-ийг баталсан эрхийн актгүй, НБББББ дэх дансны төлөвлөгөө, нягтлан бодох бүртгэлийн програмын данстай тохироогүй, ББӨ-т удирдлагын зардал болох шатахуун болон тэтгэмж урамшуулал, холбоо, бичиг хэрэг зэрэг нийт 2,966.0 мянган төгрөгийн зардлыг оруулж тооцсон нь НБББББ стандарт шаардлага хангахгүй байгааг харуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулий 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг зөрчсөн бөгөөд НББОУС, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн нийтлэг зарчмууд, Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэрэг тулгуур баримт бичгийн заалтад нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НБББББ-т өөрчлөлт хийлгэж, стандарт шаардлагыг хангаж ажиллах тухай зөвлөмж өгөх

1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага байхгүй.

1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

1.9.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Талын илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,966.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд алдаа зөрчил арилгуулах 1 зөвлөмж өглөө.

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй байна.

1.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Талын илч” ОНӨААТҮГ нь 2017 онд өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд 241,363.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 367,075.1 мянган төгрөг зарцуулж, (125,711.8) мянган төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна.

2017 оны орлого, зарцуулалтын талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Хувь	Зөрүү
1	Цэвэр ашгийн дүн	-125,711.8	-7,361.1	-94.1	-118,350.7
1.1	Нийт зардал	367,075.1	304,017.5	17.2	63,057.6
1.2	Хөрөнгийн зардал				
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл				
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	241,363.3	296,656.4	-22.9	-55,293.1
2.1	Улсын төсвөөс санхүүжих				
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Байгууллагын үйл ажиллагааны орлогоос	241,363.3	296,656.4	-22.9	-55,293.1

“Талын илч” ОНӨААТҮГ нь 2017 онд 241,363.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 367,075.1 мянган төгрөг зарцуулж, (125,711.8) мянган төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 296,656.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөгөө 22.9 % буюу 55,293.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, үйл ажиллагаандаа 304,017.5 мянган төгрөг зарцуулж, зардлыг 17.2 % буюу 63,057.6 мянган төгрөгөөр хэмнэж, (7,361.1) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан ба цэвэр ашгийг төлөвлөснөөс 94.1% буюу 118,350.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна

Орлого нэмэгдсэн нь зарим байгууллагын талбай болон цэвэр усны үнэ нэмэгдсэнтэй холбоотой бол зардал буурсан нь ашиглалтгүй хөрөнгийн элэгдлийг зогсоосонтой холбоотой байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 27,259.6 мянган төгрөг байсан ба үндсэн үйл ажиллагааны орлого 286,744.5 мянга, бусад эх үүсвэрээс 410.2 мянга, нийт 287,154.7 мянган төгрөгийн орлого бүртгэж, цалинд 61,311.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 19.6 мянга, бараа материал худалдан авахад 68,319.9 мянга, ашиглалтын зардалд 21,984.5 мянга, түлш шатахуунд 63,666.5 мянга, татварт 28,808.5 мянга, бусад зардалд 16,809.0 мянга, нийт 281,483.1 мянган төгрөг зарцуулж, 32,931.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Тус байгууллагын авлага оны эхэнд 19,080.6 мянган төгрөг байсан ба тайлант онд 105.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 19,185.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Авлагын үлдэгдэлийн 90.0% нь 36 сараас дээш хоногтой бөгөөд НӨАТ, ААНОАТ, ажилчин албан хаагчидтай холбоотой авлагууд байна.

Мөн өглөг оны эхэнд 3,725.0 мянган төгрөг байсан ба тайлант онд 3,453.6 мянган төгрөгөөр буурч, 271.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Өглөгийн үлдэгдэл төлөгдөх хугацаандаа байна.

Бараа материалын дансны 2017 оны эхний үлдэгдэл 24,665.3 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 104,932.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 87,363.9 мянган төгрөгөөр хасагдаж, 42,233.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,482,851.4 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 7,769.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,490,620.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Тайлант хугацаанд нэмэгдсэн 7,769.5 мянган төгрөгийн хөрөнгө нь ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон бөгөөд аймгийн ИТХТ-ийн 2017 оны 19, 59 дүгээр тогтоол, Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 373 дугаар албан бичгийн дагуу бүртгэлд авсан байна.

1.11 Шилэн дансны мэдээлэл

“Талын илч” ОНӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэстэй бөгөөд 20 нэр төрлийн мэдээллийг 149 удаа оруулахаас 38 мэдээллийг хугацаа хоцроож, 74.5% хэрэгжүүлсэн байна.

1.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хариуг хугацаанд нь ирүүлсэн бөгөөд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

1.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэлээ.

“Талын илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг мэдэгдье.

Асуудал 1: НБББББ-ийн ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

НБББББ-ийг баталсан эрхийн актгүй, НБББББ дэх дансны төлөвлөгөө нягтлан бодох бүртгэлийн програмын данстай тохирохгүй, ББӨ-т удирдлагын шатахуун болон тэтгэмж урамшуулал, холбоо, бичиг хэрэг зэрэг нийт 2,966.0 мянган төгрөгийн зардлыг оруулж тооцсон байна.

Энэ нь 3.1.9. “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг хэлнэ” гэж заасныг зөрчсөн бөгөөд НББОУС, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн нийтлэг зарчмууд, Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэрэг тулгуур баримт бичгийн заалтад нийцээгүй байна.

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан

А.Батжаргал
Б.Мөнх-Эрдэнэ

Зөвлөмж

Стандарт шаардлага хангасан НБББББ-тэй болох ба ББӨ-т хамааралгүй зардлыг бүртгэхгүй байх.

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга
Нягтлан

А.Батжаргал
Б.Мөнх-Эрдэнэ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хугацаа: 2017 он

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,259,629.88	32,931,210.82
1.1.02	Дансны авлага	19,080,555.89	19,185,798.94
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	8,154,121.50	6,323,413.84
1.1.04	Бусад авлага	474,953.14	-
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	24,665,321.35	42,233,794.89
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	-	-
1.1.10		-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	79,634,581.76	100,674,218.49
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,929,570,378.82	1,861,815,479.46
1.2.02	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,929,570,378.82	1,861,815,479.46
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,009,204,960.58	1,962,489,697.95
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	3,725,012.20	271,392.00
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	139,030.00	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	192,942.00	-
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	49,420.80	15,307.00
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,106,405.00	286,699.00
2.1.2.05		796,968,329.12	761,486,954.68
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	796,968,329.12	761,486,954.68
2.2	Өр төлбөрийн нийт дүн	801,074,734.12	761,773,653.68
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	1,522,156,240.20	1,522,156,240.20

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан

2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,099,664.00	1,099,664.00
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(315,125,677.74)	(322,539,859.93)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(7,419,182.22)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(315,125,677.74)	(315,120,677.71)
2.3.10		-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,208,130,226.46	1,200,716,044.27
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,009,204,960.58	1,962,489,697.95

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Хугацаа: 2017 он

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант хугацааны дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	237,782,865.95	249,229,929.00
02	Борлуулалтын өртөг	230,264,435.53	216,986,138.57
03	Нийт ашиг(алдагдал)	7,518,430.42	32,243,790.43
04	Түрээсийн орлого	-	-
05	Хүүний орлого	117,633.75	580,580.00
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	33,179,555.60	46,845,927.16
08.1	Орлогын дүн	33,297,189.35	47,426,507.16
09	Борлуулалт, маркетингийн зардал	17,108,094.30	11,564,780.74
10	Ерөнхий ба удирдлагын зардал	68,836,060.65	75,466,641.07
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	5,190,871.00	-
12.1	Зардлын дүн	91,135,025.95	87,031,421.81
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(50,319,406.18)	(7,361,124.22)
19	Орлогын татварын зардал	11,763.36	58,058.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(50,331,169.54)	(7,419,182.22)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(50,331,169.54)	(7,419,182.22)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-

Мөнгөн гүйлгээний тайлан

Хугацаа:2017

1	ᠮᠥᠩᠭᠡᠨ ᠭᠦᠢᠯᠭᠡᠭᠡᠨ	ᠠᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯᠢᠭᠠᠭᠠᠨ	ᠮᠥᠩᠭᠡᠨ ᠭᠦᠢᠯᠭᠡᠭᠡᠨ
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	324471265.7	287154655.4
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	324074528	286744490.4
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0	0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0	0
1.1.4	Буцаан авсан албан татвар	0	0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0	0
1.1.6	Бусад мөнгөн орлого	396737.73	410165.08
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	297794341.2	281483074.5
1.2.1	Ажиллагчдад төлсөн	85590923.99	61311503
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	16000000	19630134.8
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	37348364.49	68319866
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	24564023.94	21984501
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	79459567.4	63666514
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0	0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	33536325.2	28808461.69
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	15662400	953110
1.2.9	Бусад мөнгөн зарлага	5632736.2	16808984
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	26676924.46	5671580.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	26676924.46	5671580.94
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	582705.42	27259629.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27259629.88	32931210.82

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хугацаа: 2017 он

№	Үзүүлэлт	Өмч	ХөрДахҮнНэ м	ХурАшиг	Нийт дүн
01	2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,522,156,240.20	1,099,664.00	(294,112,981.12)	1,229,142,923.08
	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	29,318,472.92	29,318,472.92
03	Залруулсан үлдэгдэл	1,522,156,240.20	1,099,664.00	(264,794,508.20)	1,258,461,396.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(50,331,169.56)	(50,331,169.56)
05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
09	2016 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,522,156,240.20	1,099,664.00	(315,125,677.74)	1,208,130,226.46
	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	5,000.03	5,000.03
11	Залруулсан үлдэгдэл	1,522,156,240.20	1,099,664.00	(315,120,677.71)	1,208,135,226.49
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(7,419,182.22)	(7,419,182.22)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2017 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,522,156,240.20	1,099,664.00	(322,539,859.93)	1,200,716,044.27